

ЭДИЙН ЗАСАГ

**ХЯТАДЫН ХӨДӨӨ ТОСГОНД
ХИЙЖ БУЙ ЭДИЙН ЗАСГИЙН
ШИНЭТГЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ**

**Ц. Гэрэл
М. Нарантуяа**

Аль ч улс оронд материаллаг үйлдвэрлэлийн чухал салбарын нэг нь хөдөө аж ахуй байдаг. Социалист нийгэмд энэ салбар нийгмийн амьдралын олон талын хэрэгцээг хангахад гол үүрэг гүйцэтгэдэг учир социализмын эдийн засгийн хуулиудын шаардлагын дагуу тус салбарт нийгмийн өмчийн зонхилох хэлбэр, социализмын давуу талд түшиглэж хөдөө аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх замаар өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулдаг.

Ялангуяа хүн амын дийлэнх нь хөдөө тосгонд амьдардаг Хятад шиг оронд хөдөө аж ахуйн хөгжлөөс ард түмний материаллаг аж байдал, улс ардын аж ахуйн хөгжлийн хурдац ихээхэн шалтгаалах нь мэдээж билээ. Иймээс хөдөө аж ахуйг хөгжүүлэх нь БНХАУ-ын эдийн засгийн хөгжлийн тулгамдсан, нэн даруй шийдвэрлэвэл зохих асуудлын нэг болох нь зүйн хэрэг юм.

Гэтэл Хятадын хөдөө аж ахуй сүүлийн 20 гаруй жилийн турш тус орны удирдагчдын явуулж байсан эдийн засгийн олон янзын туршилтын талбар болсоор иржээ. Харин 1978 онд хуралдсан ХКН-ын Төв Хорооны Ш бүгд хурлаас «их үсрэлт» (1958), «соёлын хувьсгал (1966—1976) зэрэг балмад бодлогыг хянан үзэж, хөдөөд эдийн засгийн шинэтгэл хэрэгжүүлэхээр шийдвэрлэв. Шинэтгэл хийхдээ юуны өмнө олон түмний «социалист идэвх санаачлагыг дайчлан өрнүүлэх»-ийг чухалчилсан байна. Учир нь 20 гаруй жилийн турш тус оронд ардын коммуныг олноор байгуулан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгслийг хэт өмчлөн, туслах аж ахуй, хувийн аж ахуйг эрхлэхийг эрс хориглон, тэгшитгэн хувиарлах зарчмыг газар сайгүй чанд баримтлаж ирсэн нь үйлдвэрлэлийг бие даан эрхлэх буюу хийснээр даршуулах, хөдөлмөрийн идэвх чармайлт гаргахад тариачин олон түмний итгэл зоригийг мохоож, нийгмийн аж ахуйг хөтлөх социалист зарчмыг гуйвуулахад хүргэжээ. ХКН-ын Төв Хорооны III бүгд хурал (1978)-ын шийдвэрийн дагуу Хятадын олон сая тариачдын хөдөлмөрийн идэвхийг сэргээхийн тулд тэдэнд аж ахуйн бие даасан байдал олгож, материаллаг сонирхлыг нь дээшлүүлэхэд чиглэсэн нэлээд арга хэмжээ байна. Үүнд: Хөдөө аж ахуйн зарим нэгэн бүтээгдэхүүний бэлтгэлийн үнийг нэмж, улсад төлөх албан татварын хэмжээг багасгах, улсаас тариачдад олгох зээл тусламжийн хэмжээг өсгөн, хувийн аж ахуй, туслах аж ахуй эрхлэхийг зөвшөөрөн, зах зээлийг зохих хэмжээгээр чөлөөтэй болгосон байна. Эдгээр арга хэмжээ тариачдын хөдөлмөрийн идэвх санаачлагыг ямар нэг хэмжээгээр өрнүүлсэн хэдий боловч үйлдвэрлэлийн хуучин арга барил, зохион байгуулалт хэвээр байгаа нөхцөлд эдийн засгийн зохих үр ашгаа цаашид өгч чадахгүй нь тодорхой байв. Иймд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг зохион байгуулалтын хувьд үндсээр нь өөрчлөн байгуулах шаардлага үүдэн гарч, хөдөлмөрлөсний хирээр хуваарлах зарчим дээр үндэслэсэн орлогыг үйлдвэрлэлийн эцсийн үр дүнтэй холбосон «гэрээт хариуцлагын сис-

тем»-ийг нэвтрүүлэхээр тогтжээ. Энэхүү системийг хөдөө нэвтрүүлэх асуудал анх 50-иад оны эхээр тавигдаж «их үсрэлт», «соёлын хувьсгал»-ын дараа дахин сэргээж хэд хэдэн мужид (Аньхуй, Сычуань) туршилтын журмаар хэрэгжиж зохих үр дүнгээ өгсөн нь* улмаар улсын хэмжээнд нэвтрүүлэх үндэс болжээ. Энэ нь Хятадын хөдөө аж ахуйд гар хөдөлмөр голлон тариачид нь өрх гэрээрээ үйлдвэрлэлээ хөтөлж ирсэн уламжлалтай мөн холбоотой ажээ. «Гэрээт хариуцлагын систем» нь үйлдвэрлэлийн бригадын төвлөрсөн удирдлагыг өрх гэрүүдийн аж ахуйг бие даан эрхлэн хөтлөх явдалтай хослон хөдөлмөрлөснийх нь хирээр хөлс олгох журамтай бөгөөд уг системийн дагуу хэсэг бүлэг тариачид, тариачин өрх болон тариачдад газар, мал, хөдөлмөрийн багаж хэрэгслийг гэрээгээр олгоно. Гэрээгээр авсан эдэлбэр газартаа тэд үйлдвэрлэл явуулж, тодорхой хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэн, түүнийхээ нэг хэсгийг улсад татвар болгон тушааж, нөгөө хэсгийг зайлшгүй нийлүүлэх бүтээгдэхүүн болгон улсад худалдана. Мөн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний зарим хэсгийг буюу түүнтэй тэнцэх мөнгийг уг системд хамрагдагсдын хуримтлалын болон нийгмийн хэрэглээний фондод шилжүүлэх бөгөөд үлдсэн хэсэг нь үйлдвэрлэгчдийн хөдөлмөрийн хөлс болдог байна.

«Гэрээт хариуцлагын систем»-ийг хэрэгжүүлэхдээ Хятадын удирдагчид ХКН-ын Төв Хорооны 1981 оны 75 тоот баримт бичигт тус орны бүс нутгийн эдийн засгийн хөгжил, байгаль цаг уурын нөхцлийг харгалзан, тариачдын хүсэл сонирхолд нийцүүлэн эдийн засгийн хувьд хөгжилтэй бүс нутагт төрөлжсөн аж ахуйн «Гэрээт хариуцлагын систем»-ийг, дунд зэргийн хөгжилтэй бүс нутагт хамтарсан гэрээт хариуцлагын систем»-ийг, буурай хөгжилтэй бүс нутагт «өрхийн хариуцлагын систем»-ийг тус тус нэвтрүүлэхээр заажээ.

«Өрхийн хариуцлагын систем» нь анхлан дээр дурьдсанчлан эдийн засгийн хөгжлөөр дорой бүс нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан бол 1981 оны байдлаар хөдөөгийн аж ахуйн гэрээт бүх өрх айлуудын 38%-ийг хамарч, 1982 он гэхэд Хятадын хөдөө аж ахуйд дээрх хоёр хэлбэрээс давуутай хөгжиж зонхилох хэлбэр болжээ. Ийнхүү олон мянган жилийн турш хятадын хөдөө аж ахуйд зонхилж байсан жижиг тариачны аж ахуй дахин сэргэж, «өрхийн хариуцлагын систем»-д тариачин олонх өрхийг хамрах гэсэн эдийн засгийн шинэтгэлийн эхний зорилт хэрэгжсэн байна. Хөдөө аж ахуйд хийх эдийн засгийн шинэтгэлийн удаах зорилт нь «өрхийн хариуцлагын систем»-ийг гүнзгийрүүлэн хэрэгжүүлж, улмаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтцийг боловсронгуй болгох, хөдөө тосгонд таваарын аж ахуйг хөгжүүлэхэд оршиж байв. «Өрхийн хариуцлагын систем»-ийг боловсронгуй болгох зорилгоор тариачин өрхүүдийн аж ахуйн бие даасан байдлыг улам бүр бэхжүүлэхэд чиглэсэн хэд хэдэн арга хэмжээ авчээ. Үүнд: Улсад албан журмаар нийлүүлэх бүтээгдэхүүний төлөвлөгөөг биелүүлвэл үлдсэн бүтээгдэхүүнээ чөлөөтэй худалдах, тээвэр хийх, жижиг худалдаа эрхлэх, хөдөө аж ахуйн техник худалдан авах, ажиллах

* Чжао Цзыян. Вань Ли нар Аньхуй, Сычуань мужуудад (эдгээр мужуудын намын хорооны дарга нар байсан) анх «гэрээт хариуцлагын систем»-ийг хэрэгжүүлж нэлээд амжилт олжээ. Үүнийг Аньхуй мужийн Чусянь сианы Сяогань тосгоны 20 өрх «хариуцлагын систем» авч хэрэгжүүлсэн жишээн дээр харахад: 1979 оны үр тарианы үйлдвэрлэл 1966—1970 онд үйлдвэрлэсэн хэмжээтэй тэнцэж байсан байна. Тэдгээр 20 өрхийн 1 хүн тутамд ногдох орлого 1977 онд 41 юань байсан бол 1979 онд 311 юаньд хүрчээ.

хүч хөлслөх зэрэг эрхийг тариачдад олгон, улсаас хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг тогтоосон үнээр авдаг байсан бол үр тариа, хөвөнгөөс бусад бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээр авдаг болжээ. Ийнхүү тариачид нь үйлдвэрлэлээ зах зээлийн эрэлт хэрэгцээнд тохируулж эрхлэх зарим боломжтой болсон байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтцийг боловсронгуй болгох зорилтыг төрөлжсөн аж ахуй, тосгоны үйлдвэрлэлтийг хөгжүүлэх замаар хэрэгжүүлж байна. Хөдөө аж ахуйд тодорхой үйлдвэрлэл явуулдаг өрхүүд төрөлжсөн аж ахуй эрхлэх бөгөөд үүнийгээ гэрээгээр, бие даах гэсэн хоёр янзаар явуулж байна. Гэрээт төрөлжсөн эрх нь «өрхийн хариуцлагын систем»-ийн дагуу үйлдвэрлэлээ эрхэлдэг боловч шувуу, гахай, загас үржүүлэх, үр тариа, техникийн ургамал тариалах гэх зэргээр тодорхой нэг чиглэлээр үйлдвэрлэл явуулдагараа бусад өрхүүдээс ялгаатай байна. Бие даасан төрөлжсөн өрх нь хятадуудын үзэж байгаагаар «социализм дахь хувийн өмчийн хэлбэр» бөгөөд голчлон хавсарга аж ахуйг (жижиг худалдаа, тээвэр, үйлчилгээ, барилга) эрхэлдэг ажээ. 1986 оны байдлаар Хятадад 3696 сая төрөлжсөн өрх байгаа бөгөөд тэр нь хөдөөгийн нийт айл өрхийн 1,9%-ийг хамарч байна.¹ Тэдгээрийн 37% нь газар тариалан, мал аж ахуй, загасны аж ахуй, 23% нь үйлдвэр, барилга, 40% нь зам тээвэр худалдаа, үйлчилгээ эрхэлж байна.² Төрөлжсөн аж ахуйг өргөнөөр ашигласны үр дүнд хөдөө дахь аж ахуйн нэр төрөл олширч, бүтээгдэхүүний чанар сайжирч зах зээл дээр борлогдох чадвар нэлээд дээшилсэн гэж тэд үзэж байна. Тухайлбал, аж үйлдвэр, худалдаа, тээвэр, барилга, үйлчилгээ эрхэлдэг төрөлжсөн өрхүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 90 орчим хувь, газар тариалангаар төрөлжсөн өрхүүдийн бүтээгдэхүүний 50 хувь нь зах зээл дээр борлогдож байна.³

Төрөлжсөн өрхүүд нь үйлдвэрлэлээ улам боловсронгуй болгож, бүтээгдэхүүнийхээ боловсруулалт, борлуулалтын нөхцлийг сайжруулах, шинжлэх ухаан техникийн сүүлийн үеийн ололт амжилтын талаар мэдээлэл авах, шаардагдаж буй үйлдвэрлэлийн хэрэгслийг худалдаж авах бололцоотой болох зорилгоор техникийн хэрэгсэл, мөнгө хөрөнгө нэгтгэн хамтран эзэмших үндсэн дээр төрөл бүрийн аж ахуйн нэгдлүүдийг байгуулж, үйлдвэрлэлээ эрхлэн явуулж байна. 1986 оны байдлаар Хятадад 490 мянган аж ахуйн нэгдлүүд байгаа бөгөөд түүнд 4,2 сая хүн (хөдөөгийн нийт ажиллах хүчний 1,13%) ажиллаж байна.⁴ Төрөлжсөн аж ахуйг хөгжүүлснээр хөдөө аж ахуйн хөдөлмөрийн бүтээмж дээшилж, байгалийн баялгийг ашиглах явдал сайжирч, шинжлэх ухаан техникийн ололт амжилт нэвтэрч, таваарын үйлдвэрлэл хөгжин, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтэц боловсронгуй болж байна гэж Хятадын эдийн засагчид үзэж байна.

Хөдөө аж ахуйн бүтцийг төгөлдөржүүлэх зорилтыг биелүүлэхдээ тосгоны үйлдвэрлэлийг хөгжүүлэх явдлыг анхаарч байна. 1987 оны байдлаар Хятадын хөдөөд 16 сая тосгоны үйлдвэрийн газар (1984 онд 1,4 сая байсан) байгаа бөгөөд тэдгээрт 72 сая (1984 онд 52 сая) хүн ажиллаж байна.⁵ Эдгээр үйлдвэрийн газрын 70 орчим хувь нь аж үйлдвэрийн газар (хими, машин, төмөрлөг) барилгын материалын

1 «Бэйжин ревью», 1987. № 23. р. 23

2 Мөн тэнд

3 «Бэйжин ревью», № 49. р. 25

4 «Пекин сүхо», 1987. № 3

5 «Жэньминь жибао», 1987. № 23. «Чайна дейли». 1986. II.23

үйлдвэр), 13% нь барилга, 8% худалдаа, үйлчилгээ 4 %, газар тариалан, туслах аж ахуй 4%, зам тээвэр эрхэлсэн үйлдвэрийн газрууд байна.⁶ Тосгоны үйлдвэрийг хөгжүүлэх нь хөдөө аж ахуйн хөгжилд чухал ач холбогдолтой болохыг доорх баримтаас харж болох юм. Хөдөө тосгоны үйлдвэрүүд нь улсад төлөх хөдөө аж ахуйн татварын ихэнхийг (1984 онд 48,4 % байсан бол 1985 онд 69,8%)⁷ оруулж байна. Тэдгээр үйлдвэрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг голчлон хөдөө тосгонд борлуулж орлогыг хөдөө аж ахуйг механикжуулахад зориулж байна. Улсаас их хэмжээний хөрөнгө оруулах боломж багатай нөхцөлд энэ нь хөдөө аж ахуйн хөгжилд тус дөхөм болох нь мэдээж юм. Тухайлбал, сүүлийн 5 жилд хөдөө тосгоны үйлдвэрүүд хөдөө аж ахуйг хөгжүүлэх, машин төхөөрөмж худалдаж авахад 5,98 млрд. юань зарцуулсан нь мөн хугацаанд газар тариалан, загас агнуур, мал аж ахуйд улсаас оруулсан хөрөнгөөс 3 дахин их байна.⁸ Хөдөө тосгоны үйлдвэрийг хөгжүүлэх нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтцэд нааштай өөрчлөлт оруулж байна. Хятадын хөдөө аж ахуйн орлогын ихэнх нь газар тариалан, туслах аж ахуйгаас орж, тосгоны үйлдвэр маш бага хувь эзэлдэг байсан бол 1986 оны байдлаар хөдөө тосгоны үйлдвэрүүд нь нийт хөдөө аж ахуйн орлогын 30,5%-ийг (1980 онд 24,2%) оруулсан байна.⁹ Үүнээс харахад хөдөө аж ахуйд төрөл бүрийн салбарыг хөгжүүлэх зорилтыг биелүүлэхэд тосгоны үйлдвэр багагүй үүрэгтэй байна.

Хөдөө тосгоны үйлдвэрийг хөгжүүлснээр хөдөөгийн «илүүдэл» ажиллах хүчийг ажлаар хангах асуудал шийдэгдэнэ гэж Хятадын удирдагчид үзэж байна. 1987 оны мэдээгээр Хятадын хөдөө тосгонд хөдөлмөрийн чадвартай 370 сая хүн байгаагийн гуравны нэг нь ажилгүй байна.¹⁰ Хятадууд хөдөө тосгонд үйлдвэр, худалдаа, үйлчилгээг хөгжүүлснээр энэ зууны эцэс гэхэд 100—180 сая хүнийг ажлаар хангахаар төлөвлөж байна.¹¹

Ийнхүү Хятадын хөдөө тосгонд хийгдэж буй зохион байгуулалт, аж ахуйн өөрчлөлтийн үр дүнд нэлээд нааштай ахиц ажиглагдаж байна. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1986 онд 394,7 млрд. юаньд хүрч урьд оныхоос 3,5% -иар өсч, 391 сая тонн үр тариа 3,5 сая хөвөн хурааж авав. 1985 онтой харьцуулбал, мах, сүү, ноос үйлдвэрлэл 10 гаруй хувиар өссөн байна. Ингэснээр хөдөө аж ахуй гаас хөнгөн үйлдвэрт нийлүүлэх түүхий эдийн хэмжээ эрс нэмэгдэн, улс ардын аж ахуйн цаашдын хөгжилд тааламжтай нөхцөл бүрдүүлэх эх үүсвэр тавигдаж байна.

Тариачдад бие даасан байдал олгосноор хувийн аж ахуйтнууд үйлдвэрлэлийн хэрэгслийг ихээхэн хэмжээгээр худалдан авах болсон нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүний зах зээлийг урьд өмнө байгаагүй хэмжээгээр өргөтгөсөн байна. VI таван жилд (1981—1985) хөдөө аж ахуйн машины үйлдвэрүүд нь 50 млрд. юаний бүтээгдэхүүн зах зээл дээр худалдсан ба 1985 онд нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 1980 оноос 2 дахин өссөн байна.¹²

6 «Бэйжин ревью», 1985. №25

7 «Бэйжин ревью» 1987, № 3, р. 23

8 «Чайна реконстрактс» 1986, № 10, р. 25.

9 «Пекин сюхо» 1987. № 3

10 «Правда 1987. Ш. 21.

11 «Жэньминь жибао» 1987. Ш. 21.

12 «Бэйжин ревью» 1986. № 49. р. 26.

Хэдийгээр аж үйлдвэр, тэр дундаа хөнгөн аж үйлдвэр хурдан хөгжиж байгаа боловч Хятадын эдийн засагт хөдөө аж ахуй голлох байр суурийг эзэлсээр байна. Үүнийг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтаас улсад орсон орлого, мөн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг гадаадад худалдсанаас олох валютын хэмжээ жил ирэх тутам өсөн нэмэгдэж байгаагаар тодорхойлж болох юм. 1985 онд Хятадын хөдөө аж ахуйгаас улсад төрөл бүрийн албан татварын журмаар 18,83 млрд. юаний орлого орсон байна. Энэ нь 1978 оны үетэй, өөрөөр хэл бэл шинэтгэл хийхээс өмнөх байдалтай харьцуулахад 3,1 дахин өсчээ.¹³

Мөн Хятадын эдийн засагчдын үзэж байгаагаар хөдөө аж ахуйн салбарт чанарын өөрчлөлт гарч тариачдын материаллаг аж байдал, соёлын түвшин нэмэгдсэн байна. Тариачны жилийн дундаж орлого 1978 онд 120 юань байсан бол 1986 онд 424 юаньд хүрсэн байна. 1986 онд нэг хүнд 15 м² талбай ногдож байгаа нь 1985 оныхоос 1 м² аар нэмэгдсэн нь тариачны орон сууцны нөхцөл сайжрах төлөвтэй байна. Орлого өсч байгаатай уялдан материаллаг болон соёлын хэрэглээний зарлага өсчээ. 1986 онд нэг хүнд ногдох хэрэглээний хэмжээ 164,14 юань хүрч, 1985 оныхоос 16,3% -иар буюу 23,05 юаниар өссөн байна. Нэг хүнд ногдох соёлын хэрэглээний зардал 1986 онд 11,17 юань хүрсэн нь 1985 оныхоос 13,1 % буюу 9,88 юаниар илүү байна.¹⁴ Ард түмний хэрэглээний бүтцэд өөрчлөлт гарч байна. Урьд өмнө бараг бүх орлогоо хоол хүнс, хувцас хунарт зарцуулж байсан бол одоо орон сууц, өргөн хэрэглээний бараа зэрэгт нэлээд хэмжээгээр заруулдаг болжээ. Хэрэглээнд чанарын нэлээд өөрчлөлт гарчээ. Хоол хүнсэнд үр тариа голдуу хэрэглэж байсан бол гурил, мах зэргийг худалдан авах нь ихсэв. Гэвч нэг хүнд ногдож байгаа хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох мах, сүүний хэмжээ хүний бие махбодод зайлшгүй шаардагдах шинжлэх ухааны үндэслэлтэй нормоос их доогуур байна. Хувцсанд урьд өмнө голдуу даавуун хувцас хэрэглэж байсан бол одоо нийлэг болон нэхмэл эдлэл хэрэглэх нь ихэсжээ. Гэр ахуйн цахилгаан болон удаан хэрэглээний бараа-хөргөгч, телевизор, унадаг дугуй, оёдлын машин, бугуйн цаг зэргийг хэрэглэх явдал нэлээд өргөсөж байна. Ийм зарим ололт байхын зэрэгцээ хятадын хэвлэлд бичсэнчлэн шийдвэрлэвэл зохих хуучин буюу шинэ асуудлууд их байна.

Хувийн аж ахуйн хэлбэр дээр үндэслэгдсэн «гэрээт хариуцлагын систем нь хувийн өмчийн амиа аргацаасан үзлийг өсөн нэмэгдүүлэхэд түлхэц үзүүлснээрээ хамтын аж ахуйн давуу талыг үгүйсгэж, тариачдын нийгмийн ялгаврыг гүнзгийрүүлж байна. Төрөлжсөн аж ахуй, тосгоны үйлдвэр, «өрхийн хариуцлагын систем»-ийн нэвтрэлт, тархалтын хурдац нэмэгдэхийн хирээр үйлдвэрлэлээ чадамгай эрхэлж чадахгүй байгаа тариачид нь үндсэн ажил болсон газар тариалангаас хөндийрч, ашиг орлого илүүтэй тосгоны үйлдвэр, худалдаа зэрэгт шилжин ажиллахын зэрэгцээ ажилгүйчүүдийн тоог нэмэгдүүлж байна. Нөгөөтэйгүүр «Гэрээт хариуцлагын систем»-ийг авч хэрэгжүүлснээр нэг өрхөд ногдох газар тариалангийн талбай ихсэж энэ нь аажмаар газрыг чадамгай» тариачин өрхүүдийн гарт шилжүүлэн төвлөрүүлэх нөхцлийг бүрдүүлэх юм гэж тэд үзэж байна. Дээрх зүйл хятадын газар тариалангийн мэргэжилтэн нарын үзэж байгаагаар үйлд-

13 «Новое время» 1987. № 3

14 «Пекин сохо», 1987. № 11,

15 «Пекин сюхо», 1987. No 11

вэрлэлийг механикжуулах, орчин үеийн шинжлэх ухаан техникийн ололт амжилтыг бүрэн ашиглах, үйлдвэрлэлийг эрчимжүүлэх нөхцлийг бүрдүүлэхийн зэрэгцээ хөдөө аж ахуйг шинэчлэх хэтийн үндсэн нөхцлүүдийн нэгийг бүрдүүлэх ажээ. Энэ нь «Хятад маягийн», өөрөөр хэлбэл жижиг тариачны аж ахуйг эрхлэх замаар хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлоготой нь холбоотой юм.

Хөдөө аж ахуйд явуулж буй шинэтгэл нь зөвхөн ажиллах хүч ихтэй, байгал цаг уурын тааламжтай нөхцөлд байдаг болон аж ахуйгаа овсгоотой эрхэлдэг айл өрхүүдэд илүү үр ашиг өгөөж өгч байна. Харин ажиллах хүч дутмаг, эдийн засгийн талаар дорой хөгжилтэй бүс нутгийн өрхүүд нь урьдын адил ядуу зүдүү хэвээр байж улсад нийлүүлэх бүтээгдэхүүнээ ч үйлдвэрлэж чадахгүй байна. Энэ нь тариачин өрх айлуудын орлого, өмчийн ялгаврын эх үүсвэр болж хөдөө тосгоны тариачдын дунд нийгмийн шинэ хурцадмал байдлыг бий болгов. Албан ёсны тоо баримтаар Хятадад 14 сая ядуу өрх буюу 70 сая хүн (хүн амын 8%) байна. Үүнээс 22 сая тариачдын жилийн орлого 100 юаниас доош байна.¹⁵ Харин 1000 юаниас дээш орлоготой өрх нь хөдөөгийн нийт өрхийн 3,4 % -ийг эзэлж байна. ¹⁶ Үүгээр ч барахгүй хувийн жижиг аж ахуйг сэргээсэн нь хувийн амиа аргацаасан үзлийг дэвэргэж улмаар хөрөнгөтний зан суртахуунд автагдахад хүргэж байна. Ядуу тариачид чинээлэг айл өрхөд хөлслөгдөж буй нь хэдийгээр тэдний үзэж байгаагаар ажилгүй тариачдыг ажлаар хангаж байгаа боловч хүн хүнээ дарлан мөлжих үндсийг агуулж байгаа нь аюултай уршиг дагаварт хүргэх бөгөөд социалист аж ахуйн зарчимд тохирохгүй зүйл юм.

Хөдөө аж ахуйд зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн боловч Хятадын улс ардын аж ахуйн энэхүү гол салбарт аж ахуй нь хоцрогдсон, экстенсив арга барил, тэр дундаа гар хөдөлмөр зонхилж, хөдөлмөрийн бүтээмж туйлын дорой, хөдөө аж ахуйн мэргэжлийн боловсон хүчин үлэмж дутмаг зэрэг нь хөдөө аж ахуйд шийдвэрлэгдээгүй асуудал урьдын адил хэвээр байгааг харуулж байна.

Дээр дурьдсанаас үзэхэд хөдөө аж ахуйд авч хэрэгжүүлж буй шинэтгэл нь олон асуудлыг зохих ёсоор шийдвэрлэж чадаагүйн зэрэгцээ шийдвэрлэвэл зохих шинэ шинэ асуудлуудыг үүдэн гаргасныг харуулж байна.

15 «Правда», 1987. Ш. 21.

16 «Пекин сюхо». 1987. № 11.